



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/42

Баян-Адарга сум

**Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Хэнтий аймгийн засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/435 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зооноз, архаг халвдварт малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сумын хэмжээний нийт охин төлийг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын удирдамж, стандарт ажиллагааны зааврын хүрээнд уг ажлыг шуурхай зохион байгуулах, дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын явц, технологи, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Э.Оюунтунгалаг)-т, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын мэдээ тайлан, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Б.Баярцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Графикт хугацаанд нь мал үлдээлгүй дархлаажуулахыг Тахир нуур ХХК мал эмнэлгийн малын эмч С.Сугаррагчаа, Онон голын таван сүрэг ХХК мал эмнэлгийн малын эмч Т.Манлай, Гүндаа авшиг ХХК мал эмнэлгийн малын эмч Д.Оюунчимэг, Онон дуурлиг ХХК мал эмнэлгийн малын эмч Ц.Нарантуяа нарт үүрэг болгосугай.

4. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлдүүлэн, зарлан мэдээлэл хүргэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Э.Оюунтунгалаг)-т үүрэг болгосугай.

6. Төлөвлөгөөт ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Ганбат)-т даалгасугай.

~~ЗАСАГ ДАРГА:  Э.ЯХАГВАДОРЖ~~